

ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗАР

Огноо: 2019,11,18

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХЭРЭГЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХЭРЭГЛЭЛ

Төслийн дугаар: НТГ08

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Хот тохижуулах газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Хөдөлмөр хамгааллын хэрэглэл** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна. Тендер дараах багцаас бүрдэнэ.

Багц 1: Ажилчдын зуны нормын гутал

Багц 2: Ажилчдын өвлийн нормын гутал

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **10,000₮** /хорин мянган төгрөг 00 мөнгө / төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019,11,25-ны өдрийн 14 цаг 00 минутаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр /PDF/-ээр илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 11 сарын 25-ны өдрийн 14 цаг 30** минутанд нээнэ.

Дотоодын давуу эрх **тооцоно**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Орхон аймаг Баян-Өндөр сум Баянцагаан баг
Хот тохижуулах газрын байр
Харилцах алба: Санхүү,эдийн засгийн алба
Утас: +(976)- 70358944
+(976)- 99364679

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|------|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| | 2.3. | Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [1] жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт Сүүлийн [2] жил туршлагын мэдээлэл</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ul style="list-style-type: none"> • Татварын тодорхойлолт • Шүүхийн тодорхойлолт • Байгууллагын гэрчилгээ • Байгууллагын танилцуулга • Бараа бүтээгдэхүүний теникийн тодорхойлолт • Бүтээгдэхүүний дээж ирүүлэх <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [Шаардлагагүй.]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: БаянӨндөр сум, Баянцагаан баг, Хот тохижуулах газар өөрийн байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэр /PDF/-ээр илгээнэ.</p> <p>Огноо: 2019 оны 11 сарын 25 -ний өдөр</p> <p>Цаг: 14 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: БаянӨндөр сум, Баянцагаан баг, Хот тохижуулах газар өөрийн байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Хот тохижуулах газар 2 давхарт Санхүү албаны өрөө</p> <p>Огноо: 2019 оны 11 сарын 25-ний өдөр</p> <p>Цаг: 14 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 2018 он Аудитлагдсан санхүүгийн тайлан 2. 2 жилийн туршлагын мэдээлэл 3. Татварын тодорхойлолт 4. Шүүхийн тодорхойлолт 5. Байгууллагын гэрчилгээ 6. Байгууллагын танилцуулга 7. Бараа бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт 8. Үнийн санал 9. Үнэ болон нийлүүлэлтийн хуваарь

ТӨЭЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц 1: Ажилчдын зуны нормын гутал Багц 2: Ажилчдын өвлийн нормын гутал
----------	--





Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** [Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлтийг энд бичнэ.]
2. **Стандарт:** Ажлын тусгай хувцас-ерөнхий шаардлага MNS 13688:2000 стандарт
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл EN ISO 20345:2011
3. **Баглаа, боодол:** Баглаа боодол нь барааг тээвэрлэх, тээврийн хэрэгслээс дамжуулан ачих явцад үүсч болох бүх төрлийн гэмтэл ба дутагдах эрсдлээс хамгаалах шаардлагыг бүрэн хангасан байна. Барааг Худалдан авагчийн агуулах нөхцөлөөр нийлүүлнэ.
4. **Бараа хүргэх газар:** БаянӨндөр сум, Баянцагаан баг, Хот тохижуулах газар өөрийн байр.
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Зуны нормын гутал	Багц 1	219	ш	Хот тохижуулах газар	Гэрээ байгуулснаас хойш 5 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Өвлийн нормын гутал	Багц 2	50	ш	Хот тохижуулах газар	Гэрээ байгуулснаас хойш 5 хоног	Гэрээ байгуулснаас хойш 30 хоног	

БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Нийлүүлэх бараа бүтээгдэхүүний нэр		Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Техникийн тодорхойлолт	
					Мэргэжлийн онцлогт тохирсон үзүүлэлт	Ажлын шаардлагад нийцсэн тэмдэгт үзүүлэлт
1	Багц 1	Зуны нормын гутал	Хос	219	MNS 5623:2006 4x EN ISO 20345:2011	 WATERPROOF чийгний хамгаалалттай
3	Багц 2	Өвлийн нормын гутал	Хос	50	MNS 5623:2006 4x EN ISO 20345:2011	   INSULATED SLIP RESISTANT WATERPROOF - 40 C хүйтнээс хамгаалсан, хальтирдаггүй, чийгний хамгаалалттай
4	Багц 3	Зузаан бээлий	Ш	5665	MNS 5622:2011 17x	
5		Нимгэн бээлий	Ш	6142	MNS 5622:2011 17x	Таван хуруутай, нелонгүй утсаар нэхсэ
6		Маск /хүзүүвчин/	Ш	600	MNS 5620:2006 10x	Сайн чанарын
7		Гарын шингэн саван	Ш	65		5 Литерийн шингэн саван

АЖЛЫН ГУТАЛНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Утга	Мэргэжлийн онцлогт тохирсон үзүүлэлт
1	Ажлын зуны нормын гутал	Агаарын солилцоог бүрэн нэвтрүүлэх
2		Хөлсийг түргэн шингээх, гадагшлуулах
3		Чийг татахгүй
4		Халуунд халууцуулахгүй
5		Хөлийн чөлөөт байдлыг бүрэн хангасан
6		Хөнгөн
7		Ус, тосонд тэсвэртэй
8		Улны доод давхарга нь цэвэр резин буюу PU материал
9		Ул хөнгөн, чийг татахгүй, доргионы хамгаалалттай байх
10		Эдэлгээ бат бөх
11		Цахилгаанждаггүй
13		Зуузай хатуулгатай
14		Давхар оёдолтой
15		Ажлын өвлийн нормын гутал
16	Халуунд халууцуулахгүй	
17	Хүйтэнд хайрахгүй	
18	Хөлийн чөлөөт байдлыг бүрэн хангасан	
19	Хөнгөн	
20	Эдэлгээ бат бөх	
21	Цахилгаанждаггүй	
22	Түрүүтэй	
23	Зуузай хатуулгатай	
24	Давхар оёдолтой	
25	Халтирч гулгахгүй	
26	50 С-ын хүйтэнд хөлдөж хугарахгүй	
27	Улны доод давхарга нь цэвэр резин буюу PU материалаар хийгдсэн халтирахгүй байх	
28	Дээд давхарга хүйтэн тусгаарлах чадвартай материал	
29	Гурван давхар ултай	
30	Бинзен, тос, усанд тэсвэртэй	

ХЯНАСАН: ХТГ-ЫН ДАРГА

ОЮУНБАЯР

БОЛОВСРУУЛСАН: ХТГ-ЫН ХАБЭА МӨРГЭЖИЛТЭН

Г.БУЯННЭМЭХ



Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бидтендерийгхолбогдохжурмындагуубусадтендерторолцогчдодилболгохыгүүгээрзөвшөөрчбайна.
Захиалагчбиднийирүүлсэntenдерийгнууцлахаливааүүргээсбүрэнчөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Багц 1: 19,710,000 /арван есөн сая долоон зуун арван мянган төгрөг/**
Багц 2: 5,500,000 /таван сая таван зуун мянган төгрөг/
- Гэрээний үнийн дүнгийн [100]¹хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: [0,05%]
- Алдангийн нийт дүн: [10%]

¹Ихэнхтохиолдолд 100 хувьбайна. Шаардлагатайболтөлбөрийнхуваарийгөөрчилнө.

² Ихэнхтохиолдолд, нэгдолоохоногтоногдуулахалдангигэрээнийүнийн алдангийннийтдүнгэрээнийүнийндүнгийн 10 хувиастустусхэтрэхгүй. 0.5 хувиас,

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

⁴ Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]